



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 1/155

Хархорин сум

Г

Г

Дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Бруцеллёзын вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай А/29 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ц.Пүрвээ (“Дэлийн бурд” мал эмнэлгийн захирал)  
А.Сайнбилэг (“Аяган зураа” мал эмнэлгийн захирал)  
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)  
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)  
Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)  
Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)  
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)  
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)  
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)  
П.Нэндарам (8 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

2.Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртлэх хугацаанд хийж гүйцэтгэн, дүн мэдээг 09 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж, тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүлээлгэн өгөхийг (Э.Нарангарав), (Ц.Пүрвээ), (А.Сайнбилэг) нарт тус тус даалгасугай.

3.Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5.Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, ажлын явц үр дүнд хяналт тавьж, идэвхтэй тандалт хийж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Нарангарав)-д даалагсугай.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.



\* 401100309